



2018-2019 оны Тэтгэлэгт хөтөлбөрийн Удирдамж

2018-2019 оны хичээлийн жилд сурлага, урлаг, спортоор амжилттай суралцаж буй тэргүүний сурагчдад олгох тэтгэлэгт хөтөлбөрийн удирдамж.

Зорилго:

Бүх хичээлдээ идэвхитэй суралцаж, таслалт хоцролтгүйгээр бусдыгаа хошуучилсан, сурлага, урлаг, спорт, зураг, зохион бүтээх зэрэг салбарт амжилт гаргасан шилдэг тэргүүний сурагчдыг дэмжиж, тэдний авьяас, чадварыг үнэлж, дэмжин урамшуулах, алдаршуулж, бусдад үлгэр дууриалал болгож, нийт сурагчдын сурах идэвхийг нэмэгдүүлэх.

Хамрагдах хүрээ:

И Эс Эм Олон Улсын Дунд сургуулийн 3-11 дугаар ангийн сурагчид болон 2018-2019 оны хичээлийн жилд тус сургуульд элсэн суралцах хүсэлтэй 4-12 дугаар ангийн бүх сурагчид тэтгэлэгт өрсөлдөх боломжтой.

Тэтгэлэгт оролцох төрөл:

1. Сурлага /Академик/
2. Математик
3. ИВ хөтөлбөрийн анги (10-11р анги)
4. Өв тэгш сурлага хүмүүжил
5. Спорт
6. Урлаг Драм
7. Урлаг Дизайн
8. Бага сургууль (3-5р анги)

Тавигдах шаардлага:

- 2017-2018 оны хичээлийн жилд 3-11 дугаар ангийн урлаг, спорт, сурлага, ирц, хүмүүжлийн явцаар бусдыгаа хошуучилж буй сурагчид.
- Сүүлийн 2 жилд Сургууль, дүүрэг, нийслэл, аймаг, улс, олон улсын аливаа урлаг, спорт, гар зураг, зохион бүтээх, загвар зэрэг уралдаан, тэмцээнд оролцож авсан өргөмжлөл, шагнал, медалийг эх хувь эсвэл хуулбарыг авч ирэх.
- 2017-2018 оны хичээлийн жилд И Эс Эм Олон Улсын Дунд Сургуульд сурч байгаа сурагчид **2018 оны 3 дугаар сарын 26 ны** байдлаар төлбөрийн үлдэгдэлгүй байх.

- Асран хамгаалагчийн гарын үсэг бүхий тэтгэлэгт өрсөлдөхийг зөвшөөрсөн нэр холбоо барих дугаар бүхий маягтыг хураалгах.
- И Эс Эм ОУ-н Дунд сургуулийн Тэтгэлэг 1 хичээлийн жилийн хугацаанд хүчинтэй байдаг тул өмнө нь тэтгэлэг авсан сурагчид дахин бүртгүүлж өрсөлдөх шаардлагатай.

Тэтгэлэг горилогчийн анкет, материал хүлээн авах хугацаа:

Тэтгэлэгт горилогч нь хамгийн ихдээ 2 төрөлд нэрээ бүртгүүлэн өрсөлдөнө. Тэтгэлэг горилогчийн маягтыг **2018 оны 3 дугаар сарын 26-ны 8:00 цагаас** эхлэн 1:15 тоот өрөөнөөс авч бөглөх эсвэл сургуулийн вэбсайтаас маягтыг татан авч бөглөн **2018 оны 4 дүгээр сарын 7-ны 13:00 цагаас** өмнө хураалгана. Дээрхи хугацаанаас хойш илгээсэн маягтыг хүлээн авахгүй болно. (2017-2018 оны хичээлийн жилд И Эс Эм ОУДС-д суралцаж буй тэтгэлэг горилогч нь Маягт дээр анги удирдсан багш, хичээлийн эрхлэгч, сургуулийн санхүү, бүртгэлийн ажилтны гарын үсгэн зөвшөөрлийг зайлшгүй авсан байна.)

Шалгаруулалт:

Захирлын тушаалаар байгуулагдсан тусгай комисс хүлээн авсан холбогдох материалуудтай танилцан тэтгэлэг горилогчоос Англи хэлээр **2018 оны 4 дүгээр сарын 9,10 ний өдрүүдэд** аман болон бичгийн шалгалт авч дүгнэх ба зарим тохиолдолд тухайн хүүхдийн бүтэн жилийн сурлага, ирц, хүмүүжлийн явцаар шууд дүгнэж шалгаруулж болно. Тэтгэлэгийн эцсийн дүнг **2018 оны 4 дүгээр сарын 16** нд өөрийн вэб хуудас болон зарын самбарт байршуулан мэдээллэх болно.

Тэтгэлгийн хэмжээ:

Тэтгэлэгт өрсөлдөгчийн тоо, мэдлэг чадвар, урлаг спортын амжилт, шалгалтын дүн зэргийг харгалзан 2018-2019 оны хичээлийн жилийн төлбөрөөс **2 сая – 6 сая** хүртэлх төгрөгийн хөнгөлөлтийг эдлэх боломжтой.

И Эс Эм Олон Улсын Дунд Сургуулийн Захиргаа